

Монгол Улс
НЭЗХДШ-ТС-ийн баримт бичгийн боловсруулах хүрээнд олон улсын төрийн бус
байгууллагуудын төлөөллөөс санал авах уулзалт
2017 оны 9-р сарын 11

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 9-р сарын 11-нд олон улсын төрийн бус байгууллагуудын 14 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
Дүн шинжилгээний баримт бичигт ирүүлсэн санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)	Боломж: <ul style="list-style-type: none">• Уул уурхай, тус салбарт оруулсан хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлт, дэд бүтэц, ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлсэн.• Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нь хэдийгээр зарим сорилтыг бий болгосон боловч олон хүн эрүүл мэнд, боловсролын илүү сайн үйлчилгээ авах боломжийг олгосон.• Монгол улстай хил залгаа оршиж буй хоёр улсад ашигт малтмалын томоохон зах зээл бий.• Монгол улс залуучуудын орон учраас өсвөр хойч үеийнхэн улс орныг хөгжүүлэх боломжтой. Залуучуудыг гадаадын их дээд сургуульд суралцах тэтгэлэг олгож байгаа нь тэднийг шинэ санал санаачилгатай буцаж ирэх боломжийг олгож байгаа.• Монгол улсад аялал жуулчлалын боломж их бий; Зөвхөн гадаадын жуулчдад үйлчлэх аялал жуулчлалыг хөгжүүлэх төдийгүй дотоодын аялагчид/төлөвлөөгүй аялал жуулчлалын менежментийг сайжруулахад анхаарах ёстой.• Улс орны эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах газар болон өмчийн эрхийн асуудлуудыг харгалзан үздэг болсон.• Мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох асар их боломжтой.• Сайн эрдэмтэн, судлаачид их байна.• Ардчиллыг хөгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэлтэй, ардчиллын зөв замд орсон.• Бие даасан хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй.

- Иргэний нийгэм идэвхтэй.
- Мэдээллийн технологийн ур чадварыг экспортлох боломжтой.
- Зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадварыг хөгжүүлж бүрэн хангахад мэргэжлийн боловсрол, сургалтыг ашиглах боломжтой.

Сорилтууд:

- Улс орны тулгамдсан асуудлуудыг цогцоор нь экологийн хувьд ойлгох нь сорилт байв.
- Зах зээлд илүү чиглэсэн эдийн засгийг бий болгох.
- Төсвийн орлогыг төрөлжүүлж, солонгоруулах нь сорилт юм. Салбарын төрөлжилт дутмаг, хангалтгүй. Салбарын хөгжил, эдийн засгийг төрөлжүүлэхэд саад болж буй гол бэрхшээл нь бодлогын шинжтэй бэрхшээлүүд байв.
- Хүн ам цөөн байгаа нь сорилт мөн. Томоохон хэмжээний үйлдвэрлэл тохиромжгүй; иргэдийг багаас нь сургах нь боломжийг бүрдүүлнэ. Иймд бага насны хүүхдийн боловсрол; ялангуяа хөдөөгийн хүүхдүүдийн боловсрол нэн чухал асуудал мөн. Их дээд сургууль төгсөгчид гол төлөв төрийн албанд ажиллах сонирхолтой байдгаас бусад салбарын хүний нөөцийн хэрэгцээг хангахад бэрхшээлтэй байна.
- Засаглал, улс төр нь том сорилт мөн. Засаглалын салбарт ил тод байдал, хариуцлагын тогтолцооноос гадна төсвийн засаглал, худалдан авалт нь шийдвэрлэвэл зохих чухал асуудлууд болж байна. Одоогийн байдлаар төрийн удирдлага, улс төр хоорондын ялгаа алга болсон. ЖДҮ гэх мэт зорилтот бүлгүүдэд хуваарилсан санхүүжилт эзэндээ хүрдэггүй, иймд засаглал, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай.
- Хотжилт аливаа төлөвлөлтгүйгээр хурдацтай өсч байгаа асуудал болж байна. Иймд төвлөрлийг сааруулах ажлыг дэмжих нь сайн бодлого байх болно. Хот, хөдөөгийн ажилгүйдлийн ялгаа их байна.
- Уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн буй орчны доройтол нь асуудал үүсгэж байна, жишээ нь цөлжилт, агаарын хэмийн өөрчлөлт, ган, зуд гэх мэт.
- Хөдөө аж ахуйн салбарын жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилтийн хүртээмж хангалтгүй.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хооронд ур чадварын зөрүү гарсан; Дадлагажуулах, дагалдан сургалтын хөтөлбөр дутмаг байгаагаас сургуульд сурсан ур чадвараа ажлын байранд ашиглах боломж хязгаарлагдмал, сургуульд сурсан ур чадвар ажлын байранд шаардлагатай ур чадварын хэрэгцээ шаардлагатай нийцдэггүй.
- Эмзэг бүлгийн хувьд ажил хөдөлмөр эрхлэх боломж улирлын чанартай; Иймд эмзэг бүлгийн иргэдэд тогтвортой, урт хугацааны ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох нь сорилт болж байна.
- Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахын тулд аялал жуулчлалын салбарт – аюул осолгүй жолооч, чадварлаг, мэдлэгтэй хөтөчийн үйлчилгээ гэх мэт үйлчилгээг шинэ шатанд гаргаж сайжруулах шаардлагатай байна.
- Мал амьтны эрүүл мэндийн байдал нь мал аж ахуйн экспортын боломжид саад учруулж байна.

	<ul style="list-style-type: none"> • Төрийн албаны чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтэд сурталчлах нь чухал байна. • Тэгш бус байдал нь ядуурлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Улс орны хэмжээнд хүүхдийн ядуурал их байна.
<p>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн талаар ирүүлсэн санал</p>	<p>Дэмжих чиглэлүүд: Сорилт бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ төрийн албаны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн сайн засаглалыг бэхжүүлэхэд туслах</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхийн зэрэгцээ олон нийтийг чадавхжуулах. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр төрийн албаны чадавхийг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлэх. • Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагыг дэмжих. Нийгмийн мэдээллийн хэрэгслээр (сошиал медиа) дамжуулан нөлөөллийн арга хэмжээ авах. • Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхэд туслах. • Тогтвортой санхүүжилтийн санаачилгыг хэрэгжүүлэх, жишээ нь ногоон санхүүжилтыг илүү хүртээмжтэй болгох
	<p>Арга барил, хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • ДБГ нь хөгжлийн түншүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог ханган зохицуулах/манлайлах, чиглүүлэх үүргийг гүйцэтгэж болох юм. Бие даасан хараат бус үйл ажиллагаатай ДБГ нь оролцогч талуудын хооронд харилцан ойлголцлыг бий болгож, сайн харилцааг бэхжүүлэхэд тусалж чадна. • Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах замаар томоохон зээл тусламжийн төслүүдийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаж ажиллах. Түүнчлэн буцалтгүй тусламжийн төслүүдийг дотоод, гадаадын ТББ-аар дамжуулан хэрэгжүүлэхэд уян хатан ханддаг байдлыг үргэлжлүүлэх, үүнийг олон улсын бусад санхүүжүүлэгч байгууллагууд хүлээн зөвшөөрдөггүй. • Аливаа тусламж, хүчин чармайлт давхардахаас зайлсхийх. • Хариуцлага, ил тод байдлыг сайжруулахын тулд төслийн мониторинг, хэрэгжилтийг сайжруулах; аливаа санхүүжилтыг зориулалтын дагуу ашиглаж буйг хянан баталгаажуулах. Үр өгөөж хүртэгсдийг оновчтой тодорхойлох явдлыг сайжруулах. • Орон нутгийн хувьд чухал ач холбогдолтой, тэдний оролцоо хариуцлагыг нэмэгдүүлсэн олон тооны төслүүдийг хэрэгжүүлэх, жишээ нь орон нутаг/ дүүргийн хэмжээнд төслүүдийг хэрэгжүүлэх. • Засгийн газарт их хэмжээний зээл олгохдоо сайн засаглалыг бэхжүүлэх, авилгалтай тэмцэх чиглэлээр тодорхой шаардлага бүхий бага хэмжээний бүрэлдэхүүн оруулж байх нь зүйтэй юм. Эсвэл сайн засаглалыг бэхжүүлэх, авилгалтай тэмцэх, ил тод байдлыг сайжруулах талаар зарим арга хэмжээ авахыг зээл олгох урьдчилсан нөхцөл болгох замаар төр, засгийн газартай үр дүнтэй хамтран ажиллах.

	<ul style="list-style-type: none"> Олон улсын түвшинд амжилттай, амжилтгүй хэрэгжүүлсэн бодлогын сургамжийн талаар мэдээлэл өгөх, ингэснээр бусад орны туршлагаас сургамж авч, алдааг давтахгүй байх боломжтой болно.
--	--

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

- Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Төрийн удирдлага, засаглал/шинэтгэл	9	90%
— Боловсрол	5	50%
— Авилгатай тэмцэх	6	60%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	3	30%
— Байгалийн нөөцийн удирдлага	3	30%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	5	50%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	3	30%
— Хөдөөгийн хөгжил	1	10%
— Эрүүл мэнд	1	10%
— Эдийн засгийн өсөлт	4	40%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	2	20%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	1	10%
— Хүнсний аюулгүй байдал	0	0%
— Эрх тэгш боломжоор хангах	2	20%
— Санхүүгийн зах зээл	0	0%
— Гадаадын хөрөнгө оруулалт	0	0%
— Зам, тээвэр	0	0%
— Худалдаа, экспорт	0	0%
— Хотын хөгжил	1	10%
— Нийгмийн хамгаалал	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Ус, ариун цэврийн байгууламж	1	10%
— Уур амьсгалын өөрчлөлт	1	10%
— Бусад:	0	0%

- Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Хүний хөгжлийг дэмжих	5	50%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	2	20%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	4	40%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	6	60%
— Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	1	10%
— Бүгд чухал	4	40%